



ДОРНОГОВЬ АЙМАГ
ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 01 өдөр

Дугаар А/237

Борхойн тал

Газар эзэмшүүлэх цахим дахин дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалт, 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Засгийн газрын 2026 оны 45 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 6/11 дүгээр тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07/34 дүгээр тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх цахим дахин дуудлага худалдааг 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2.Байгууллага, иргэдэд цахим дахин дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэх газрын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмшүүлэх цахим дахин дуудлага худалдааг зохих журмын дагуу бэлтгэн зохион байгуулахыг Газрын даамал (Ж.Бат-Оргил)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Мөнхбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.САЙНБАЯР

Сумын Засаг даргын 2026
оны 04 дугаар сарын 02 өдрийн
2637 дугаар захирамжийн хавсралт



НИЙТИЙН ЦАХИМ ДАХИН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ
ЖУРМААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН ЖАГСААЛТ

д/д	Төлөвлөл тийн нэгж талбар	Газрын байршил	Газрын зориулалт	Газрын хэмжээ м. кв	Анхны үнэ /төгрөг/	Данчин /төгрөг/
1.	4873690	Жаргалант баг, 48 га дахин төлөвлөлт, 4-р сургуулийн урд талд, авто замын урд талд	2201: 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц	3000	7 200 000	720 000
2.	4873726	Жаргалант баг, 48 га дахин төлөвлөлт, Соёмбо 10 дугаар гудамжны зүүн талд	204: Амины орон сууц	12300	7 380 000	738 000
3.	4873773	Жаргалант баг Логистикийн төвийн гүүрны баруун хойд талд	3202: Авто тээврийн хэрэгслийн зогсоолын талбай	20000	48 000 000	4 800 000
4.	5099585	Соёмбо баг, 6 хэсэг 6-4 тоот	2201: 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц /хашаа, байшинтай/	246	1 476 000	147 600